

**РАДИО УДИРДЛАГАТ НИСЭХ ЗАГВАРЫН  
АГААРЫН ТУЛАЛДААНЫ ДҮРЭМ**

**1. Зорилго.**

Радио удирдлагат нисэх загварын агаарын тулалдаан (цаашид “Агаарын тулалдаан” гэх)-ыг тэмцээнд оролцогч тамирчид, үзэгчдэд сонирхолтой, өрсөлдөөнтэй болгох, тэмцээнийг аюулгүй зохион байгуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

**2. Ерөнхий зүйл**

Энэхүү тэмцээнд МАСА-ийн радио удирдлагат нисэх загварын тамирчид, загвар болон загварын бусад тоног төхөөрөмжийн талаар мөрдөгдөж буй дүрэм журмыг дагаж мөрдөнө.

Тэмцээнд оролцогч тамирчид МАСА-ийн нислэгийн аюулгүй байдлын хуудсанд гарын үсэг зурах ба тэмцээний үеэр аюулгүй байдлыг хангах, тамирчны хувьд биеэ зөв авч явах үүрэг хүлээнэ.

Энэхүү дүрмийг зөрчсөн тамирчныг Ерөнхий шүүгч (ЕШ)-ийн шийдвэрээр тэмцээнээс хасна. ЕШ-ийн шийдвэр эцсийх байх ба тамирчин энэхүү шийдвэрийн талаар гомдол гаргах эрхгүй.

Загвар болон түүнд сурилуулсан тоноглолд энэхүү дүрэмд зааснаас бусад аливаа хязгаарлалтыг тавихгүй.

Тамирчин тэмцээний нэг үед зөвхөн нэг загвараар нислэг үйлдэнэ.

Тэмцээнд оролцох загваруудын жин, хөдөлгүүрийн багтаамж болон нислэгийн аюулгүй байдал хангасан эсэхийг урьдчилан шалгасны үндсэн дээр ЕШ-ийн зөвшөөрснөөр загварыг тэмцээнд оруулна.

**2.1. Аюулгүй байдал.** ЕШ тэмцээний үед нислэгийн аюулгүй байдлыг хангахыг тамирчид, үзэгчдээс шаардлах эрхтэй.

Тэмцээний талбайд нисэгчийн (аюулгүйн) шугам болон үзэгчдийн шугамыг тодорхой тэмдэглэсэн байвал зохино. Тэмцээнд оролцож буй загварын хөдөлгүүрийн багтаамжийн 1 куб см дутамд 10 метрээр бодож тогтоосноос багагүй зайнд үзэгчдийг байрлуулна.

Тэмцээний нислэгийн үед үзэгчдийн шугамаас дотогш нэвтэрч буй хэн боловч хамгаалалтын малгай (дуулга) өмссөн байвал зохино.

**3. Загварт тавигдах шаардлага**

Дүрмийн энэхүү хэсэгт заасан шаардлагыг хангаж буй загварыг тэмцээнд оролцохыг зөвшөөрнө.

**3.1. Төрөл, ангилал.** Агаарын тулалдааны тэмцээн чөлөөт загварын, дуураймал загварын гэсэн 2 төрөлтэй байна.

**3.1.1. Чөлөөт загварын тэмцээн дараах ангилалтай байна. Үүнд:**

Ангилал	Хөдөлгүүрийн максимум багтаамж, куб см	Жингийн дээд хязгаар, гр	Цахилгаан хөдөлгүүрт загварын жингийн дээд хязгаар, гр
½ А	1,0	900	900
А	2,5	1135	1360
В	5,0	1590	1820
С	7,7	2270	2270

Олон хөдөлгүүрт загварын хөдөлгүүрүүдийн нийлбэр багтаамж нь тухайн ангилалд заасан хэмжээнд багтаж байвал тэмцээнд орохыг зөвшөөрнө.

3.1.2. Дуураймал загвар нь 1935-1955 үйлдвэрлэгдсэн болон ашиглагдаж байсан угтан сөнөөгч, сөнөөгч, дайрагч онгоцны 1:12 масштабын дуураймал загвар байна. Зөвхөн өөрийгөө хамгаалах зориулалт бүхий буутай онгоцыг угтан сөнөөгч, сөнөөгч, дайрагч онгоц гэж үзэхгүй.

Загварын хэмжээ нь энэхүү дүрэмд заасан масштабаас 10 хуртэл хувиар зөрж болно.

Загварын жинхэнэ онгоцтойгоо адил төстэй байдлыг ЕШ ердийн хараагаар тодорхойлно. Шаардлагатай бол жинхэнэ онгоцны 3 проекцын зураг, эсвэл фото зургийг тамирчнаас шаардан авч харьцуулж болно.

Загварын нислэгийн чадавхийг сайжруулах зорилгоор бага зэргийн нэмэлт төхөөрөмж хийхийг зөвшөөрөх ба энэхүү төхөөрөмж нь загварын жинхэнэ онгоцтойгоо адил төстэй байдлыг мэдэгдэхүйц алдагдуулаагүй байх хэрэгтэй.

Загварыг жинхэнэ онгоцны болон онгоцыг ашиглаж байсан анги, нэгтгэлд хэрэглэж байсан өнгөөр будна. Жинхэнэ онгоцны ер бусын өнгийн будагтай зураг зэрэг баримт байгаа бол загварыг тийм өнгөөр будаж болно.

Загварын их бие гурван хэмжээтэй (хавтгай биш) байх ба хөдөлгүүр болон дуу намсгагч их биеэс гадагш цухуйсан байж болно.

Загвар дугуйтай байж болно. Гэхдээ эвхэгддэггүй дугуйтай онгоцны дуураймал загвараас бусад загварт заавал дугуйтай байхыг шаардахгүй. Загвар будаж гаргасан, эсвэл хийсэн кабинтай байна.

Загварын жин ба хөдөлгүүрийн багтаамж дараах хүснэгтээр тодорхойлогдоно.

Хөдөлгүүрийн тоо	Далавчны далайц, см	Загварын жингийн дээд хязгаар, гр	Хөдөлгүүрийн нийлбэр багтаамж, куб см
Нэг хөдөлгүүртэй		1590	4,3
Олон хөдөлгүүртэй	127 ба түүнээс бага	1815	5,0
	127-оос их, 152 ба түүнээс бага	2040	
	152-оос их	2270	

Олон хөдөлгүүртэй загварын над зах нь хоёр хөдөлгүүр нь ажилладаг байх ёстой. Загварын 2 хөдөлгүүр загварын их бие дээр байрладаг бол нэг нь ажилладаг байж болох бөгөөд энэхүү дүрмийн нэг хөдөлгүүртэй загварт тавих шаардлагад нийцэж байх ёстой.

3.2. Хөдөлгүүрт тавигдах бусад шаардлага. Ердийн болон резонатор хоолой бүхий дуу намсгагч хэрэглэхийг шаардах ба тэдгээрийн урт нь 20 см-ээс ихгүй байвал зохино. Загварт 2 болон 4 тактын, дизель зэрэг энэхүү дүрэмд заасан багтаамж бүхий ямар ч хөдөлгүүр ашиглаж болно. Загварын жин батарейн хамт энэхүү дүрэмд заасан шаардлагад нийцэж байвал цахилгаан хөдөлгүүр ашиглаж болно.

Хөдөлгүүрт заавал кок тависан байна.

Тамирчин нислэгийн үед хөдөлгүүрийг дурын үед радиогоор удирдан унтраах боломжтой байх ёстой.

3.3. Нэмэлт төхөөрөмж. Өрсөлдөгчийн туузыг таслахад тус нэмэр болох аливаа нэмэлт төхөөрөмжийг загварт суурилуулахыг хориглоно. Харин наалдамхай бодис хэрэглэхийг зөвшөөрнө.

## 4. Тэмцээн явуулах журам

4.1. Тэмцээний талбай. Агаарын тулалдааны талбар нь тэмцээний тухайн талбайн онцлогийг харгалзан ЕШ-ээс тогтоосон, 125 м-ээс багагүй өргөн бүхий талбар байна.

Агаарын тулалдааны талбарыг заагласан нисэгчийн буюу аюулгүйн шугамыг татах ба тамирчид, шүүгчид энэхүү шугамд байрлана.

Нисэгчийн (аюулгүйн) шугамаас тэмцээнд оролцож буй загварын хөдөлгүүрийн багтаамжийн 1 куб см тутамд 10 м-ээр бодож тогтоосноос багагүй зайд үзэгчдийн шугамыг татах ба үзэгчид энэхүү шугамын гадна байрлана.

Тэмцээний нислэгийн үед зөвхөн дуулга бүхий тамирчид, шүүгчид үзэгчдийн шугамаас дотогш нэвтрэн орохыг зөвшөөрнө.

Тэмцээний аливаа загвар хөөрөх, нисэх, буух үедээ нисэгчийн шугам давахыг хориглоно.



**4.2. Тэмцээний нислэгийн үе (даваа).** Тэмцээн доод тал нь 4 үе нислэгээс бүтнэ. Нэг үед 4 ба түүнээс дээш загвар нисч тулалдана. Нэг тамирчин 4-өөс доошгүй үед нислэг хийнэ. Үүний дараа тамирчдын авсан онооны нийлбэрийг тодорхойлж, хамгийн их нийлбэр оноо бүхий тамирчныг ялагчаар тодруулна. Тамирчдын нийлбэр оноо тэнцвэл өмнөх үеүдийн нийлбэр оноогоор ялагчийг тодорхойлно. Өмнөх үеүдийн нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд тамирчидтай зөвшилцсөний үндсэн дээр ЕШ финалын тулалдаан зарлах, эсвэл хүрээнд буух тэмцээн зарлаж энэхүү тэмцээний дүнгээр ялагчийг тодруулж болно.

18 ба түүнээс дээш тооны тамирчин тэмцээнд оролцсон тохиолдолд ЕШ-ийн шийдвэрээр урьдчилсан 4 ба түүнээс дээш үе, финалын 3 ба түүнээс дээш үе болгон тэмцээнийг зохион байгуулж болно. Урьдчилсан үеүүдийн нийлбэр оноогоор финалд оролцох тамирчдын тоо нийт тамирчдын  $\frac{1}{2}$ -ээс ихгүй,  $\frac{1}{3}$ -ээс багагүй байна. Финалд оролцсон тамирчдын нийлбэр оноог тодорхойлохдоо урьдчилсан үеүүдийн нийлбэр онооны  $\frac{1}{2}$  дээр финалын үеүүдийн нийлбэр оноог нэмнэ.

**4.3. Гараа (Хөөрөлт).** Загварыг гараас, харвагчаар болон дугуйгаар нь гүйлгэн агаарт гаргаж болно. Нисэгч тамирчин бүр нэг туслахтай байж болно.

**4.4. Нислэгийн үе.** Нислэгийн үе дараах үе шатуудтай байна.

**4.4.1. Бэлтгэл үе шат.** Тамирчин бүр нэг шүүгчтэй байгаа эсэхийг ЕШ шалгаж магадлана. Үүний дараа 1 минутын бэлтгэл хугацаа зарлана.

**4.4.2. Гараа.** Бэлтгэл үе шат дуусмагц “хөдөлгүүр асаах/хөөрөх” дохиог өгснөөр загварыг агаарт гаргах 90 секундын хугацаа эхэлнэ. Сүүлийн загвар агаарт гарснаар, эсвэл дохио өгснөөс хойш 90 секундын хугацаа өнгөрснөөр энэхүү үе шат дуусна. Энэ үед тулалдаан хийж болохгүй. Хөдөлгүүр асаах, хөөрөх хугацаа дуусмагч тулалдаан эхлэх дохио өгнө.

4.4.3. Тулалдаан. Тулалдаан үргэлжлэх хугацаа 5 минут байна. Тулалдаан эхлэх дохио өгснөөр тулалдааны хугацаа эхэлж, оноог тоолж эхлэх ба тулалдаан дуусах дохио өгснөөр тулалдааныг болон оноо тоолохыг зогсооно.

ЕШ тэмцээний цагийг барьж, тулалдааны үе эхэлснээс хойш өнгөрсөн хугацаа, тулалдааны үе дуусах хүртэлх хугацааг тухай бүр зарлан мэдэгдэж байна. ЕШ болон шүүгч нар тамирчдад загвараа тулалдааны талбарын голд, аюулгүйн шугамаас тогтоосон зай, өндөрт нисгэхийг сануулж, шаардлага тавина.

4.4.4. Дахин хөөрөх. Тамирчны загвар хөөрөлтийн үед агаарт гарч чадаагүй, эсвэл тулалдааны үед буусан бол загварыг очиж авах, дахин хөөргөхийг хориглоно.

4.4.5. Буулт. Тулалдаан зогсоох дохио өгсний дараа загваруудыг тулалдааны талбайд буулгана. Түлш багатай болсон загварыг эхний ээлжинд буулгах боломж олгоно.

4.5. Загвар солих. Тамирчин нэг үеийн явцад загвараа солихыг хориглоно. Үеүүдийн хооронд загвараа солихыг зөвшөөрөх ба харин тухайн тамирчин тэмцээний явцад радио удирдлагын үелзлээ солихыг хориглоно.

4.6. Тэмцээний үеийн шалгалт. Тэмцээний үед ЕШ, эсвэл түүний эрх олгосон этгээд нислэгийн аюулгүй байдал хангаагүй гэж үзсэн аливаа загварыг өөрийн үзэмжээр шалгах эрхтэй. Ийнхүү шалгахад тухайн загвар нислэгийн аюулгүй байдлыг хангаагүй нь тогтоогдвол уг загварт засвар хийж, дахин шалгуулан тэнцэх хүртэл тэмцээнд оруулахгүй. ЕШ аливаа загварыг шалгаад гаргасан шийдвэр эцсийх байх ба энэ талаар тамирчин гомдол гаргах эрхгүй. Харин ийнхүү шалгасны дараа засвар хийж, шалгуулахаар хүссэн загварыг ЕШ шалгах үүрэгтэй.

4.7. Нислэгийн тууз. Нислэгийн туузыг ЕШ тавьж олгоно. Туузыг цаасаар хийж хөвөн даавуун утсаар загварын сүүлэнд бэхэлнэ. Туузны урт 10 м, өргөн 1,6-2,5 см байх ба утасны урт 1,5 м-ээс багагүй байна. Цаг уурын нөхцлөөс шалтгаалан энэхүү дүрэмд заасан тууз ашиглах боломжгүй бол ЕШ-ийн шийдвэрээр туузыг өөр төрлийн материалаар хийн ашиглаж болно.

## 5. Албаны хүмүүс

5.1. Ерөнхий шүүгч (ЕШ). ЕШ, эсвэл түүний эрх олгосон этгээд тэмцээний талбайн бэлэн байдлыг хангаж, тэмцээнд оролцох бүх загварын аюулгүй байдал, жин, хөдөлгүүрийн багтаамжийг шалгана.

ЕШ, эсвэл түүний эрх олгосон этгээд тэмцээний бүх цаг, хугацааг барьж, холбогдох дохиог өгнө. ЕШ, эсвэл түүний эрх олгосон этгээд тамирчдын оноог шүүгч нараас авч, энэхүү дүрэмд заасны дагуу дүгнэнэ. Мөн тэмцээний туузыг тавьж олгоно.

5.2. Шүүгчид. Тэмцээний тухайн үед нисч буй загвар (тамирчин) бүр нэг шүүгчтэй байна. Шүүгч өөрт ногдсон тамирчны авсан болон алдсан оноог нислэгийн хуудсанд тэмдэглэнэ. Загварыг газардсаны дараа таслагдаагүй үлдсэн туузны уртыг хэмжиж оноог тодорхойлно.

## 6. Оноо

### 6.1. Нэмэх (Өгөх) оноо

Тууз таслах бүрт	+ 100
Заагдсан 90 секундын дотор агаарт гарах	+20
Тулалдааны 5 минутад үргэлжилсэн нислэг	+20
Таслагдаагүй үлдсэн туузны 30 см тутамд	+4 (+120-оос дээшгүй)

## 6.2. Хасах оноо

<i>Тулалдаанаас зайлсхийх</i> Хэт өндөрт, эсвэл тулалдааны талбараас хэт хол нисвэл тулалдаанаас зайлсхийсэн гэж үзэж 1 удаа сануулах ба хоёр дахь сануулгаас эхлэн сануулга тутамд 25 оноо хасна. Хэт доогуур нисэхийг тулалдаанаас зайлсхийсэнд тооцохгүй.	- 25
<i>Аюулгүйн (нисэгчийн) шугам зөрчих (давах)</i> Аюулгүйн шугамыг 1 удаа зөрчвөл сануулж, 200 оноо хасна. Тухайн тулалдааны үед аюулгүйн шугамыг дахин зөрчвөл амаар мэдэгдэн 200 оноо хасч, тулалдааны тухайн үед авсан бүх нэмэх оноог хүчингүй болгон, загварыг яаралтай буулгах ба уг загварыг тулалдааны тухайн үед дахин нисгэхгүй.	-200 -200
<i>Үзэгчдийн шугамыг зөрчих (давах)</i> Үзэгчдийн шугамыг 1 удаа зөрчвөл амаар мэдэгдэн тулалдааны тухайн үед авсан бүх нэмэх оноог хүчингүй болгож, 300 оноо хасан загварыг яаралтай буулгах ба тулалдааны тухайн үед дахин нисгэхгүй. Үзэгчдийн шугамыг тухайн тэмцээний явцад 2 дахь удаагаа зөрчвөл тулалдааны тухайн үед авсан бүх нэмэх оноог хүчингүй болгож, 300 оноо хасан загварыг яаралтай буулгах ба тухайн тэмцээнд дахин нисгэхгүй.	- 300 - 300

6.3. Туузыг гээх. Туузыг өрсөлдөгчийн тасалснаас бусад ямар нэг замаар гэмтээсэн бол туузыг гээсэнд тооцно. Туузыг гээсэн, эсвэл бүрэн задраагүй туузтай агаарт гарсан бол загвар бүрэн бус туузтай ниссэнд тооцно. Энэ тохиолдолд уг тамирчинд нэмэх оноо өгөхгүй. Харин уг загвар хугацаандаа агаарт гарсан бол хугацаандаа гарсны оноог өгнө. Загвар тулалдааны 5 минутын туршид ниссэн бол үргэлжилсэн нислэгийн оноо өгнө. Тулалдаан эхэлснээс хойш агаарт гарсан, тулалдаан дуусахаас өмнө газардсан загварт үргэлжилсэн нислэгийн оноо өгөхгүй.

6.4. Агаарт мөргөлдөх. Агаарт мөргөлдсөн загвар тулалдааныг орхиж, тулалдааны талбараас дээш, зүүн, эсвэл баруун тийш боломжтой зүг гарах ёстой. Агаарт мөргөлдсөн загварыг “сөнөсөнд” тооцож аливаа оноо өгөхгүй (хасахгүй). Агаарт мөргөлдсөний улмаас загвар унасан бол үргэлжилсэн нислэгийн +20 оноо өгнө. Агаарт мөргөлдсөн загварыг тамирчин аюулгүй жолоодож тулалдааны талбараас гаргасны дараа тамирчин болон шүүгч уг загвар тулалдааныг аюулгүй үргэлжлүүлэх боломжтой гэж үзсэн бол загварыг “сөнөөгүй” гэж тооцон тулалдаанд буцаан оруулж, оноо өгч (хасч) эхэлнэ. Хэрэв уг загвар тулалдааныг аюулгүй үргэлжлүүлэх боломжгүй бол тамирчин загвараа тулалдааны талбайд яаралтай буулгах ба тамирчинд үргэлжилсэн нислэгийн +20 оноо өгнө. Загварыг аюулгүй буулгах боломжгүй бол тамирчин загвараа тулалдааны талбараас алс зайд нисгэж, тулалдаан дуусч бүх загварууд буусны дараа гэмтсэн загвараа буулгана. Энэ үед шүүгч “Анхаар-агаар” гэсэн дохио өгөх үүрэгтэй.

Хөөрөх үед мөргөлдсөн загварыг гараанд гараагүй гэж тооцно.

6.5. Хүрээнд буух. ЕШ-ийн шийдвэрээр тулалдааны дараа загваруудыг тодорхой хүрээнд буулгаж, ийнхүү буусан загварт +25 оноо өгч болно. Загвар тухайн хүрээнд газардаж, мөн хүрээнд зогссон бол хүрээнд буусан гэж үзнэ. Буух хүрээний хэмжээ, байрлалыг ЕШ тогтооно.

### 6.6. Туузыг таслах.

6.6.1. Тулалдаан эхлэх дохионоос дуусах дохио өгөх хүртэлх хугацаанд нэг загвар нөгөө загварын туузны тодорхой хэсгийг (эсвэл бүгдийг) тасалсныг тууз тасалсан гэж үзнэ.

6.6.2. Тууз таслах бүрт тууз тасалсны оноо өгнө.

6.6.3. Тууз тасалсныг шүүгч харж, зарлах ба шүүгчийн энэ шийдвэр эцсийх байна.

6.6.4. Тулалдааны явцад хоёр тууз бие биедээ хүрсний улмаас аль нэг нь тасарсан бол нөгөө тамирчинд тууз тасалсны оноо өгнө.

6.6.5. Тулалдааны явцад хоёр тууз бие биедээ хүрсний улмаас хоюул тасарсан бол хоёр тамирчинд хоюуланд нь тууз тасалсны оноо өгнө.

6.6.6. Нэг туузыг нэг дайралтаар хэд хэдэн удаа тасалсан бол нэг тасалсан гэж үзнэ.

6.6.7. Загвараас салсан туузыг тасалсан бол оноо өгөхгүй.

#### 6.7. Тасраагүй үлдсэн туузанд оноо өгөх

6.7.1. Тулалдааны дараа тасраагүй үлдсэн туузанд оноо авахын тулд загвар бүрэн бүтэн, бүрэн дэлгэгдсэн туузтайгаар тулалдааны талбарт орсон байх шаардлагатай.

6.7.2. Мөн оноо авахын тулд тулалдааны дараа тууз нь утсандаа, утас нь загвартаа бэхлэгдсэн хэвээр загвар бууж ирсэн байх ёстой.

6.7.3. Тулалдааны дараа үлдсэн туузын уртыг тодорхойлохдоо хамгийн ойр 30 см-т бууруулан шилжүүлж бүхэлчлэн тогтооно.

6.8. Аюулгүйн (нисэгчийн) болон үзэгчдийн шугам зөрчих. Аюулгүйн (нисэгчийн) болон үзэгчдийн шугам зөрчсөний хасах оноог тус бүрт нь тооцно. Жишээ нь, тамирчны загвар аюулгүйн (нисэгчийн) болон үзэгчдийн шугамыг хамтад нь зөрчсөн бол -200 болон -300 оноо, нийт -500 оноо хасна.

## РАДИО УДИРДЛАГАТ ЗАГВАРЫН АГААРЫН ТУЛАЛДААНЫ НИСЛЭГИЙН ХУУДАС

Тамирчны нэр .....

Шүүгчийн нэр .....

Нислэгийн үе	Хугацаандаа гарсан (+20)	Үргэлжилсэн нислэг	Тууз тасалсан (тус бүр +100)					Аюулгүйн (нисэгчийн) шугам давсан (-200) <small>Аюулгүйн шугамыг 1 удаа зөрчвөл сануулж, 200 оноо хасна.</small>	Үзэгчдийн шугам давсан (-300) <small>Тухайн үед авсан бүх нэмэх оноог хүчингүй болгон, загварыг буулгах ба тулалдааны тухайн үед дахин нисгэхгүй.</small>	Тулалдаанаас зайлсхийсэн (-25)	Тасраагүй үлдсэн тууз (30 см тутамд +4)	Үеийн нийт оноо	Тамирчин, шүүгчийн гарын үсэг	
			<small>Таслах бүр доорх нүдэнд тэмдэглэнэ.</small>					<small>2 дахь удаагаа зөрчвөл 200 оноо хасч, тухайн үед авсан бүх нэмэх оноог хүчингүй болгон, загварыг буулгах ба тулалдааны тухайн үед дахин нисгэхгүй.</small>	<small>Хоёрдахь удаагаа давбал 300 оноо хасч, тухайн үед авсан бүх нэмэх оноог хүчингүй болгон, загварыг яаралтай буулгах ба тэмцээнээс хасна.</small>				Тамирчин	Шүүгч
1	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
2	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
3	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
4	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
5	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
6	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
7	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
8	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
9	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
10	+20	+20						-200 -200	-300 -300	-25	+ .....оноо			
<b>НИЙТ ОНОО</b>														

ТЭМЦЭЭНИЙ ЕРӨНХИЙ ШҮҮГЧ \_\_\_\_\_ /

/